



**ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН “ОХИДЫГ ХҮЧИРХИЙЛЭЛ, МӨЛЖЛӨГӨӨС
ХАМГААЛАХ НЬ” ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ/ТӨСЛИЙН ТУСЛАХ АЖИЛТАН СОНГОН
ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Улс	Монгол
Зөвлөх үйлчилгээ эхлэх огноо	2024 оны 1 дүгээр сарын 15
Гэрээ үргэлжлэх хугацаа	4 сар
Байршил	Улаанбаатар хот
Шууд удирдлага	ХХХЭЗХ-үүдийн менежер, Төслийн зохицуулагч
Цалин хөлс	Сар тутам
Зөвлөхийн орон тоо	1 зөвлөх
Ажлын нөхцөл	Оффис
Child Safeguarding: Level 3 – the responsibilities of this post may require the post holder to have occasional contact with children and young people.	

Агуулга

Хүүхдийг Ивээх Сан нь хүүхдийн эрхийг хангах, түүнийг хэрэгжүүлэх замыг боловсронгуй болгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, ашгийн бус, шашны бус, олон улсын төрийн бус байгууллага юм. Хүүхдийг Ивээх Сан нь НҮБ-ийн Итгэлцлийн Сангийн санхүүжилттэйгээр “Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төслийг 2021-2024 онд гурван жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Тус төсөл нь Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 12-18 насны охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсролын үйлчилгээгээр дамжуулан хамгаалах зорилготой. Мөн жөндөрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр салбар дундын уялдаа холбоог бэхжүүлэх, тухайлбал боловсролын байгууллагуудыг татан оролцуулах, хүүхдийн оролцоог дэмжих, жөндөрт суурилсан хүчирхийллийн мэдээлэл цуглуулах ажлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилт тавин ажиллаж байна.

“Охидыг хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалах нь” төсөл нь дараах дөрвөн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хохирогчид ээлтэй, гэмтлийн дараах сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх 11 модуль бүхий сургалтын гарын авлага, арга зүйг зөвлөх үйлчилгээний мэргэжлийн багуудтай хамтран боловсруулж, хүүхэд хамгааллын салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулах
2. Зорилтот таван дүүргийн сонгогдсон 15 ЕБС-ийн удирдлага, багш нарыг модулийн агуулгын хүрээнд сургаж чадавхжуулахаас гадна өсвөр үеийнхнийг жөндөрт суурилсан хүчирхийллээс (ЖСХ) урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг хүүхдүүд өөрсдийн сургууль дээр зохион байгуулах үйл ажиллагааг дэмжих.
3. “Чи ганцаараа биш” нөлөөллийн ажлыг цахим орчинд зохион байгуулж, олон нийтийн сүлжээ, гар утасны аппликэйшн, мессежээр дамжуулан өсвөр насны охидод чиглэсэн хэрвээ гэртээ, сургууль дээрээ, олон нийтийн орчинд ямар нэг хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хаана, хэнд хандах, хэрхэн тусламж авах тухай мэдээлэл, зөвлөгөөг хүргэх ажлыг зохион байгуулах

4. Төсөл хэрэгжих хугацаанд төслийн хяналт, үнэлгээний ажлын хүрээнд суурь судалгаа, нөхцөл байдлын үнэлгээ, мэдлэг, хандлага, дадлын үнэлгээг хийн, хүүхэд хамгаалал, түүний тоон мэдээлэл цуглуулах бүтэц, тогтолцоонд учирч буй асуудал бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх арга замуудын талаар зөвлөмж, удирдамжийг боловсруулан шийдвэр гаргагчдад хүргүүлэх.

Үнэлгээ/төслийн туслах ажилтны үндсэн ажил үүрэг:

1. Төслийн эцсийн шатны үнэлгээ хийхэд төслийн багт дэмжлэг үзүүлж ажиллах, төслийн бичиг баримт архивлах;

Үнэлгээ/төслийн туслах ажилтны гүйцэтгэх ажлын жагсаалт:

Үнэлгээ/төслийн туслах ажилтан нь үндсэн ажил үүргийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ:

- Төслийн эцсийн шатны үнэлгээ хийхэд төслийн багт дэмжлэг үзүүлж ажиллах
- Төслийн бичиг баримтыг цаасан болон цахим хэлбэрээр архивлах, хадгалах
- Сургалт, уулзалт зохион байгуулах гэх мэт төслийн үйл ажиллагаанд төслийн баг болон зөвлөхүүдэд дэмжлэг үзүүлж ажиллах
- Хөтөлбөрийн болон төслийн өдөр тутмын ажилд дэмжлэг үзүүлж ажиллах
- Төслийн бичиг баримтыг англи хэл рүү орчуулах
- Хөтөлбөрийн менежер болон төслийн зохицуулагчаас өгсөн нэмэлт үүрэг, даалгавруудыг биелүүлэх

Зөвлөхөд тавигдах мэргэжлийн ур чадвар:

- Нийгмийн ажил, боловсрол болон бусад ижил төстэй чиглэлээр бакалаврын зэрэгтэй байх
- Хүүхэд хамгааллын салбарт ажиллаж байсан бол давуу тал болно.
- Бичиг баримт боловсруулах, архивлах ажил хийж байсан туршлагатай байх
- Англи болон монгол хэлний бичгийн ур чадвартай байх,
- Олон улсын болон соёлын ялгаатай багт ажиллаж байсан туршлагатай байх,

Бусад ур чадвар:

Мэргэжлийн ур чадвараас гадна дараах чадваруудыг эзэмшсэн байх шаардлагатай. Үүнд:

- Багаар ажиллах
- Санаачилгатай
- Харилцааны ур чадвар
- Хэрэглээний программуудад чөлөөтэй ажиллах чадвар
- Жендэрийн болон соёлын мэдрэмжтэй байх
- Үр дүнтэй хамтрагч, үйлчлүүлэгчид чиглэсэн арга барил эзэмшсэн
- Салбар хоорондын сэтгэлгээтэй

Тендерийн материалын тавигдах шаардлага:

Үнэлгээ/төслийн туслах ажилтны ажлын шаардлагыг хангасан хувь хүн дараах баримт бичгүүдийг англи, монгол хэлээр бэлтгэн ХИС-д ирүүлнэ. Үүнд:

- Сонирхол илэрхийлсэн захидал
- Намтар (CV)